



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 116/17

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/02 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 4.2.1.1, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах” 07/08 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах”-зорилтот жилийн хүрээнд бүрэн шаталттай, түлшний хэмнэлттэй 2 ширхэг зуухыг худалдан авч турших зардалд 1,040,000 (нэг сая дөчин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Зуухны туршилтын үр дүнг 2022 оны 02 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Б.Оюунчимэг), Арвайхээр сумын Засаг дарга (Б.Ганбат) нарт тус тус үүрэг болгосугай

3.Дээрх зардлыг зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй..



А.ИШДОРЖ

6222 11 0015

D:My Doc. Zahiramj. Zasag darga